



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/583

Мөрөн сум

Газар эзэмших эрх дуусгавар болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/59 дүгээр захирамжийн хавсралтын 3 дахь заалтаар газар эзэмшигч хуулийн этгээд "Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар" (9070192)-ны Мөрөн сум 10 дугаар баг 6712016520 нэгж талбарын дугаартай эрүүл мэндийн байгууллагын зориулалтаар эзэмшүүлсэн 2635 м² газрын газар эзэмшигч "Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар" нь газар эзэмших гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу газар эзэмших эрхийг нь дуусгавар болгож нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байсан газар эзэмшигч хуулийн этгээд "Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар" (9070192)-ын 0000014628 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээ, Мөрөн сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/59 дүгээр захирамжийн хавсралтын 3 дахь заалтыг тус тус хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ